

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХЭНТИЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ,
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2026/146/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он
Цахим хуудас: www.audit.mn

Тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112
Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390
Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг khentii@audit.gov.mn хаягаар авна уу

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
3.1 Төлбөрийн акт	12
3.2 Албан шаардлага	12
3.3 Зөвлөмж	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 433
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭМНЭЛГИЙН
П.АНХМАНДАХ ТАНАА

НЭГДСЭН
ЗАХИРАЛ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас 15,056.0 сая төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт, орон нутгийн төсвөөс 1,518.2 сая төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт авч, төсөвт байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 902.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 18,051.0 сая төгрөгийг зарцуулж, тогтмол зардлын санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 20.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж үйлчилгээний санхүүжилт өмнөх оноос 228.6 сая төгрөгөөр буурсан, тогтмол зардлын санхүүжилт 87.7 сая төгрөгөөр, өр төлбөрийн үлдэгдэл 466.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас 15,799.6 сая төгрөгийн тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс 5 хувь буюу 754.7 сая төгрөгийн санхүүжилт явцын хяналтаар хасагдсан байгаад анхаарал хандуулж цаашид дотоод хяналтыг сайжруулж, нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авах, өр төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 33.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс цалин, нэмэгдэл илүү олгосон 28.3 сая төгрөг, байгууллагын төсвөөс спортын тэмцээн зохион байгуулсан 5.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 8 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 89 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,852,423,249.01	720,368,627.97
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	598,073,031.12	3,464,997.18
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	598,073,031.12	3,464,997.18
3121	Төгрөг	598,073,031.12	3,464,997.18
31211	Төрийн сангийн харилцах	598,073,031.12	3,464,997.18
33	АВЛАГА	206,266,349.17	10,753,643.14
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	42,626.17	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	206,223,723.00	10,753,643.14
35	БАРАА МАТЕРИАЛ	1,048,083,868.72	706,149,987.65
351	Түүхий эд материал	725,324,397.02	325,961,643.55
35110	Тусгай зориулалттай материал	2,300,000.00	19,930,194.00
35130	Эм боох материал	723,024,397.02	306,031,449.55
354	Хангамжийн материал	320,929,471.70	379,658,344.10
35410	Бичиг хэргийн материал	17,710,150.00	13,543,450.00
35420	Аж ахуйн материал	62,957,535.00	69,690,870.00
35430	Сэлбэг хэрэгсэл	110,321,032.10	165,109,782.10
35440	Түлш, шатах тослох материал	113,400.00	7,172,200.00
35450	Барилгын засварын материал	44,142,472.00	50,305,130.00
35460	Хүнсний материал	8,478,300.00	4,429,130.00
35470	Бусад хангамжийн материал	77,206,582.60	69,407,782.00
35600	Мал амьтад	1,830,000.00	530,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	25,251,429,849.08	24,826,627,387.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	25,251,429,849.08	24,826,627,387.89
392	Биет хөрөнгө	24,383,318,445.02	23,934,613,258.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,400,979,312.00	22,249,327,758.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,963,991,157.10)	(2,340,981,036.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,086,682,062.72	1,021,182,062.72
39204	Хуримтлагдсан элэгдэл	(186,469,212.16)	(250,101,443.03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,615,453,180.16	14,067,702,668.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,690,012,072.77)	(10,984,726,814.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	547,161,789.77	317,540,772.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(426,485,457.60)	(145,330,708.92)
393	Биет бус хөрөнгө	868,111,404.06	892,014,129.04
39301	Програм хангамж	16,213,700.00	11,020,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(11,302,295.94)	(7,206,370.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	863,200,000.00	888,200,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	27,103,853,098.09	25,546,996,015.86
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	2,596,708,669.49	3,063,514,049.22
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,596,708,669.49	3,063,514,049.22
413	Өглөг	2,150,204,244.49	3,063,514,049.22
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	239,216,697.12	678,110,726.81
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,873,142,207.37	2,366,452,022.12
4136	Бусад өглөг	37,845,340.00	18,951,300.29
41361	Байгууллагад төлөх өглөг	37,825,340.00	18,931,987.18
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	20,000.00	19,313.11
414	Урьдчилж орсон орлого	446,504,425.00	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	446,504,425.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,507,144,428.60	22,483,481,966.64
51	Засгийн газрын хувь оролцоо	24,507,144,428.60	22,483,481,966.64
511	Засгийн газрын оруулсан капитал	4,930,425,368.06	4,955,425,368.06
51101	Өмч: - төрийн	4,930,425,368.06	4,955,425,368.06
512	Хуримтлагдсан үр дүн	19,003,656,460.02	16,954,993,998.06
51210	Өмнөх үеийн үр дүн	19,003,656,460.02	19,003,656,460.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	(2,048,662,461.96)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	573,062,600.52	573,062,600.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	27,103,853,098.09	25,546,996,015.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	18,115,838,487.83	19,339,504,099.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,149,695,079.83	2,514,285,779.77
120	Нийтлэг татварын бус орлого	1,149,695,079.83	2,514,285,779.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,149,695,079.83	2,514,285,779.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	352,221,754.55	424,788,887.05
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,060,000.00	477,434,305.87
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	791,413,325.28	1,612,062,586.85
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,966,143,408.00	16,825,218,320.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,430,469,600.00	1,518,163,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,430,469,600.00	1,518,163,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,535,673,808.00	15,307,054,820.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,535,673,808.00	15,307,054,820.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	19,985,929,729.40	21,388,166,561.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,985,929,729.40	21,388,166,561.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,978,229,729.40	20,882,537,148.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,348,450,068.74	11,331,554,788.52
210101	Үндсэн цалин	5,306,799,670.72	5,983,729,830.97
210102	Нэмэгдэл	4,070,658,068.52	4,260,231,154.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	374,472,544.32	631,592,103.19
210104	Урамшуулал	596,519,785.18	456,001,699.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,430,646,342.54	1,542,536,960.22
210201	Тэтгэврийн даатгал	1,030,271,606.56	1,042,730,570.43
210202	Тэтгэмжийн даатгал	99,869,223.86	126,273,014.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	53,567,590.28	85,600,115.47
210204	Ажилгүйдлийн даатгал	49,367,430.22	61,594,408.08
210205	Эрүүл мэндийн даатгал	197,570,491.62	226,338,851.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,414,520,600.00	1,433,102,487.18
210301	Гэрэл, цахилгаан	199,267,010.29	241,745,947.18
210302	Түлш, халаалт	961,790,472.09	952,373,070.00
210303	Цэвэр, бохир ус	253,463,117.62	238,983,470.00
2104	Хангамж, бараа материалын зардал	267,552,201.39	328,638,379.00
210401	Бичиг хэрэг	35,444,350.00	49,103,000.00
210402	Тээвэр, шатахуун	139,007,160.00	124,299,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,811,913.79	29,115,682.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	11,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,288,777.60	114,919,937.00
2105	Нормативт зардал	3,837,766,113.11	3,932,945,561.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,367,108,693.11	3,483,689,794.15
210502	Хоол, хүнс	428,513,970.00	407,077,916.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	42,143,450.00	42,177,850.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	144,085,248.77	123,066,042.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,681,222.00	6,497,100.00
210604	Урсгал засвар	129,404,026.77	116,568,942.00
2107	Томилолт, зочны зардал	36,438,690.00	38,490,295.00
210702	Дотоод албан томилолт	36,438,690.00	38,490,295.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	245,314,678.04	108,142,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	212,014,040.04	80,295,650.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	5,360,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	10,437,655.00	4,517,840.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	731,929.00	485,370.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,292,079.00	16,779,702.00
210807	Газрын төлбөр	838,975.00	406,988.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,253,455,786.81	2,044,060,085.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,955,000.00	1,629,312.86
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,248,500,786.81	2,042,430,772.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,700,000.00	505,629,412.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,700,000.00	505,629,412.76
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	327,836,992.76
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	149,598,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,700,000.00	28,194,420.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(1,870,091,241.57)</u>	<u>(2,048,662,461.96)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(1,870,091,241.57)</u>	<u>(2,048,662,461.96)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>18,544,785,116.55</u>	<u>17,476,407,168.03</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	358,281,754.55	902,223,192.92
120	Нийтлэг татварын бус орлого	358,281,754.55	902,223,192.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	358,281,754.55	902,223,192.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	352,221,754.55	424,788,887.05
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,060,000.00	477,434,305.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,186,503,362.00	16,574,183,975.11
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,430,469,600.00	1,518,163,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,430,469,600.00	1,518,163,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,756,033,762.00	15,056,020,475.11
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,756,033,762.00	15,056,020,475.11
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>17,624,660,430.43</u>	<u>18,071,015,201.97</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,624,660,430.43	18,071,015,201.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,616,960,430.43	17,545,224,776.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,334,082,866.74	10,913,810,516.00
210101	Үндсэн цалин	5,292,432,468.72	5,305,842,189.94
210102	Нэмэгдэл	4,070,658,068.52	4,645,299,290.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	374,472,544.32	362,849,503.88
210104	Урамшуулал	596,519,785.18	599,819,531.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,226,326,922.71	1,521,256,766.88
210201	Тэтгэврийн даатгал	868,053,322.71	1,105,862,419.09
210202	Тэтгэмжийн даатгал	89,568,400.00	105,808,329.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	44,784,200.00	64,946,596.74
210204	Ажилгүйдлийн даатгал	44,784,200.00	55,153,094.71
210205	Эрүүл мэндийн даатгал	179,136,800.00	189,486,326.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,438,692,621.50	1,433,102,487.18
210301	Гэрэл, цахилгаан	194,966,670.29	241,745,947.18
210302	Түлш, халаалт	975,390,679.59	952,373,070.00
210303	Цэвэр, бохир ус	268,335,271.62	238,983,470.00
2104	Хангамж, бараа материалын зардал	338,470,713.79	339,457,704.00
210401	Бичиг хэрэг	45,739,800.00	38,691,300.00
210402	Тээвэр, шатахуун	153,924,000.00	131,358,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,856,013.79	29,115,682.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	11,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	134,950,900.00	129,092,162.00
2105	Нормативт зардал	3,770,648,291.88	2,941,676,857.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,139,133,261.88	2,530,543,635.38
210502	Хоол, хүнс	591,515,030.00	378,170,721.95
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,000,000.00	32,962,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	215,853,745.77	249,387,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,346,805.00	116,208,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	1,550,000.00
210604	Урсгал засвар	171,006,940.77	131,628,700.00
2107	Томилолт, зочны зардал	36,438,690.00	36,790,295.00
210702	Дотоод албан томилолт	36,438,690.00	36,790,295.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	256,446,578.04	109,742,550.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,396,051.04	81,895,650.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	34,300,686.00	5,360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,437,655.00	4,517,840.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	795,499.00	475,370.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	307,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,677,712.00	16,779,702.00
210807	Газрын төлбөр	838,975.00	406,988.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,700,000.00	525,790,425.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,700,000.00	505,729,412.76
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	900,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	363,062,992.76
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	114,372,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,800,000.00	28,294,420.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	20,061,012.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	20,061,012.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>920,124,686.12</u>	<u>(594,608,033.94)</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	331,963,500.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	331,963,500.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	331,963,500.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	331,963,500.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(331,963,500.00)</u>	=
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	588,161,186.12	(594,608,033.94)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,911,845.00	598,073,031.12
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	598,073,031.12	3,464,997.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,930,425,368.06	573,062,600.52	19,003,656,460.02	24,507,144,428.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,930,425,368.06	573,062,600.52	19,003,656,460.02	24,507,144,428.60
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,930,425,368.06	573,062,600.52	19,003,656,460.02	24,507,144,428.60
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,930,425,368.06	573,062,600.52	19,003,656,460.02	24,507,144,428.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,930,425,368.06	573,062,600.52	19,003,656,460.02	24,507,144,428.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	25,000,000.00	-	-	25,000,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,048,662,461.96)	(2,048,662,461.96)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,955,425,368.06	573,062,600.52	16,954,993,998.06	22,483,481,966.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,561,347,600.00	18,050,954,189.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,561,347,600.00	18,050,954,189.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,990,571,200.00	17,545,224,776.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,422,080,400.00	10,913,810,516.00
210101	Үндсэн цалин	5,800,158,300.00	5,305,842,189.94
210102	Нэмэгдэл	4,699,010,500.00	4,645,299,290.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	442,952,600.00	362,849,503.88
210104	Урамшуулал	479,959,000.00	599,819,531.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,497,882,900.00	1,521,256,766.88
210201	Тэтгэврийн даатгал	1,011,116,200.00	1,105,862,419.09
210202	Тэтгэмжийн даатгал	121,691,700.00	105,808,329.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	60,845,800.00	64,946,596.74
210204	Ажилгүйдлийн даатгал	60,845,800.00	55,153,094.71
210205	Эрүүл мэндийн даатгал	243,383,400.00	189,486,326.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,468,163,500.00	1,433,102,487.18
210301	Гэрэл, цахилгаан	254,760,900.00	241,745,947.18
210302	Түлш, халаалт	943,402,600.00	952,373,070.00
210303	Цэвэр, бохир ус	270,000,000.00	238,983,470.00
2104	Хангамж, бараа материалын зардал	431,200,000.00	339,457,704.00
210401	Бичиг хэрэг	80,000,000.00	38,691,300.00
210402	Тээвэр, шатахуун	130,000,000.00	131,358,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,000,000.00	29,115,682.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,200,000.00	11,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000,000.00	129,092,162.00
2105	Нормативт зардал	2,653,673,700.00	2,941,676,857.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,248,673,700.00	2,530,543,635.38
210502	Хоол, хүнс	380,000,000.00	378,170,721.95
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,000,000.00	32,962,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	268,499,800.00	249,387,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	120,000,000.00	116,208,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	1,550,000.00
210604	Урсгал засвар	146,499,800.00	131,628,700.00
2107	Томиллолт, зочны зардал	38,333,600.00	36,790,295.00
210702	Дотоод албан томиллолт	38,333,600.00	36,790,295.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	210,737,300.00	109,742,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	175,000,300.00	81,895,650.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	5,360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,000,000.00	4,517,840.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,000,000.00	475,370.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,000,000.00	307,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,897,000.00	16,779,702.00
210807	Газрын төлбөр	840,000.00	406,988.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	570,776,400.00	505,729,412.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	570,776,400.00	505,729,412.76
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	400,060,400.00	363,062,992.76
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	140,316,000.00	114,372,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,400,000.00	28,294,420.00
213403	Төвлөрүүлэн шилжүүлэг		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,561,347,600.00	17,456,346,155.21
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,518,163,500.00	1,498,102,487.18
132001	Орон нутгийн төсвөөс	1,518,163,500.00	1,498,102,487.18
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,482,835,000.00	15,056,020,475.11
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,482,835,000.00	15,056,020,475.11
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,560,349,100.00	902,223,192.92

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	421,899,600.00	424,788,887.05
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	540,376,400.00	477,434,305.87
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	598,073,100.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		598,073,031.12
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,464,997.18

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,471.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлэв. тогтоосон.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

3.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлаас өндөр насны тэтгэвэр тогтоолгон төрийн албаны харилцаа дуусаж, шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй 18 ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувь буюу дээд хэмжээгээр тооцон 22,440.8 мянган төгрөг, батлагдаагүй орон тоонд өмгөөлөгч авч ажиллуулан цалинд 5,870.6 мянган төгрөг, нийт 28,311.5 мянган төгрөгийг олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсалтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 3-д “Төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацаанд дараахь хугацааг оруулж тооцно” гэсэн заалтыг зөрчсөн байна;
2. Байгууллагын төсвөөс спортын тэмцээн зохион байгуулж 5,160.0 мянган төгрөгийн шагнал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	0										

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин, нэмэгдэл илүү олгосон	1	28,311.5			1	28,311.5						
Дүн	1	28,311.5			1	28,311.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Зөрчил илрээгүй								
Дүн	0	0						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1	5,160.0			1	5,160.0		
Дүн	1	5,160.0			1	5,160.0		
Нийт дүн	1	5,160.0			1	5,160.0		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 213 - А2370449

Чингис хот

ХЭА - 2026/146/НА - СТА - ТШЗ

Зөрчлийг таслан тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас өндөр насны тэтгэвэр тогтоолгон төрийн албаны харилцаа дуусаж, шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй 18 ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувь буюу дээд хэмжээгээр олгож 22,440,840.00 /хорин хоёр сая дөрвөн зуун дөчин мянга найман зуун дөч/ төгрөгийг, батлагдаагүй орон тоонд өмгөөлөгч авч ажиллуулан цалинд 5,870,630.00 /таван сая найман зуун далан мянга зургаан зуун гуч/ төгрөгийг, нийт 28,311,470.00 /хорин найман сая гурван зуун арван нэгэн мянга дөрвөн зуун дал/ төгрөгийг олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсалтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 3-д "Төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацаанд дараах хугацааг оруулж тооцно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомж зөрчин төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн захирал П.Анхмандах-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25

Дугаар 214-А2370449

Чингис хот

ХЭА-2026/146/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын төсвөөс спортын тэмцээн зохион байгуулж 5,160,000.00 /таван сая нэг зуун жаран мянга/ төгрөгийн шагнал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомж зөрчин төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нэгдсэн эмнэлгийн захирал П.Анхмандах-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Х.ЕРКЕГҮЛ

